

ӨГҮҮЛЭЛ

**БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл,
экспортоо дэмжиж буй хэлбэрүүд****Дашдаваагийн Мягмар** 

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
myagmar_d@mas.ac.mn

Хураангуй: Уг судалгаа нь БНСУ-ын экспортыг дэмжих чиглэлд олсон амжилт, туршилагаас Монгол Улсад хэрэг болохуйц зарим жишээг тодруулах зорилго агуулсан. Энэ хүрээнд эхний хэсэгт 1960-аад оноос эхлэн хэрэгжүүлсэн аж үйлдвэрлэл, гадаад худалдааг хөгжүүлэх зарим онцлох бодлого хөтөлбөрүүдийг тоймлон судаллаа. Хоёрдугаар хэсэгт 2000 оноос хойш хэрэгжүүлж буй жишээг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортыг дэмжих хөтөлбөрүүдийн ерөнхий агуулга, хэлбэр, хэрэгжүүлэх арга барилийг судлав. Тухайлбал экспортыг дэмжих санхүү, маркетинг, технологийн үйлчилгээнүүд, тэдгээрийн онцлог, хэрэгжүүлж буй арга барилуудыг зарим жишээтэй оруулсан. Судалгааны үр дүнд тус улсын аж үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлсэн туршилага, өнөөгийн байдлаар хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрүүдээс Монгол Улсын экспортыг дэмжих үйл хэрэгт нэмэр болохуйц зарим жишээг гаргалаа.

Түлхүүр үгс: БНСУ, экспорт, үйлдвэрлэл, жишээг дунд үйлдвэрлэгч, бодлого, хөтөлбөр

Оршил

Монгол Улсын эдийн засгийг тулгуурлан дотоодын үйлдвэрлэл, түүхий эдийн экспортын хараат экспортыг дэмжих шаардлагатай. байдлаас гаргахын тулд улс орны Манай улс өнөөгийн байдлаар онцлог, давуу тал, нөөц боломжид аж үйлдвэрлэл, гадаад худалдааг



дэмжих нэгдсэн тууштай бодлогогүй, хариуцсан яамдын уялдаа холбоо сул, бодлого хэрэгжүүлэх мэргэшсэн байгууллага цөөн, экспортыг дэмжих хөтөлбөр, арга хэрэгсэл дутмаг байна. Түүнчлэн гадаад худалдааны дэд бүтэц сул, үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнийг гадаадад сурталчлан таниулах үйлчилгээ хомс байдалтай байна. Эдгээр сул талуудаа нөхөж, тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэхэд аж үйлдвэрлэл, экспортыг дэмжиж эдийн засгийн өндөр амжилтад хүрсэн улс орнуудын туршлагаас суралцах

нь ихээхэн тустай. Бидний стратегийн түнш БНСУ нь харьцангуй богино хугацаанд хүнд болон хөнгөн аж үйлдвэрлэлийг хөгжүүлсний дүнд эдүгээ дэлхийн томоохон экспортлогч орон болж чадсан. Тус улсын өндөр технологи, хүчирхэг эдийн засгийг бий болгосон туршлагаас суралцах зүйл бидэнд олон байгаа юм. Энэ хүрээнд тус улсын урьд өмнө хэрэгжүүлж байсан болон өнөөгийн байдлаар хэрэгжүүлж буй үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүдээс тоймлон судаллаа.

1. Өмнө нь хэрэгжүүлсэн зарим бодлого, хөтөлбөрүүд

Солонгосын дайны дараа буюу 1950-аад оны дунд үед БНСУ-д аж үйлдвэрлэл бүрэн устаж, ард иргэдийн хүнсний хангамжийн асуудал нэн хүнд байсан учир хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд гол анхаарлаа хандуулсан байна. Улмаар аж үйлдвэрлэлд тулгуурлан эдийн засгаа хөгжүүлэх бодлого баримталж, 1960 оноос импортыг орлох өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг дэмжихийн хажуугаар хүнд аж үйлдвэрлэлийн дэд бүтцийн ажлыг эхлүүлжээ. 1970-аад оноос хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг төрөөс бодлогоор дэмжих болсноор тус улсын экспортын хэмжээ хурдацтай нэмэгдсэн. БНСУ-ын Засгийн газар 1962 оноос “Эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө”-г тав таван жилээр төлөвлөн 1992 он хүртэл харилцан уялдаатайгаар 6 удаа хэрэгжүүлжээ¹.

1.1 Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого

1970 оноос Хүнд болон химийн аж үйлдвэрлэл (химийн, электроникийн, метал болон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл)-ийг төрөөс дэмжиж эхэлсэн бөгөөд уг бодлогын хүрээнд Поханы ган хайлуулах үйлдвэр, Улсаны газрын тос боловсруулах аж үйлдвэрийн цогцолборууд бий болжээ. Хүнд болон химийн аж үйлдвэрлэл нь харилцан уялдаа холбоотой, нэг нь үгүй бол үр ашгаа бага өгдөг онцлогтой учир цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай байдаг аж. Бодлогын үндсэн хэсэг болох “Гадаадын зээлийг дэмжих журам”-ын хүрээнд Засгийн газраас нэр заасан тодорхой тооны үйлдвэрлэгчид гадаадаас хөнгөлөлттэй зээл авах тохиолдолд зээлийн баталгааг Засгийн газар гаргаж өгдөг байв. Төрийн баталгаа бүхий гадаадын

¹ 경제 개발 5개년 계획 (naver.com)

хөнгөлөлттэй зээлийн жилийн хүү нь дунджаар 9 хувь буюу дотоодын банкнуудынхаас (зээлийн хүү 20 орчим хувь байсан) хавьгүй бага, эргэн төлөх хугацаа урт байсан нь үйлдвэрлэгчдэд үлэмж давуу тал олгожээ. Хөтөлбөрт хамрагдсан компани нь зээлийн гэрээний нарийвчилсан нөхцөл болон зарцуулалтаа Засгийн газарт тайлагнадаг, Засгийн газар нь эргээд хяналт тавьдаг журамтай байв. 1979 оноос бодлогын хоёрдугаар шатанд тус улсын зүүн өмнөд бүсэд байрших аж үйлдвэрийн цогцолборуудыг Засгийн газрын баталгаа бүхий гадаадын хөнгөлөлттэй зээлээр дэмжиж эхэлжээ.

1.2 “Төвлөрсөн худалдаа эрхлэгч” хөтөлбөр

1975 оноос хэрэгжүүлсэн Төвлөрсөн худалдаа эрхлэгч (ТХЭ) нэртэй хөтөлбөр нь олон улсын худалдаа, бизнесийн орчин сайнгүй байсан тухайн цаг үед гадаад худалдааны томоохон сүлжээ, борлуулалтын суваг үүсгэх, гадаад зах зээлийн мэдээллийн бааз суурь бий болгох, худалдаагаар дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдсэн. Энэ нь Япон улсын өмнө хэрэгжүүлж байсан экспортыг дэмжих “Sogo shosha” хөтөлбөртэй төстэй. Уг хөтөлбөрт хамрагдах компанийн экспортын хэмжээ нь БНСУ-ын нийт экспортын 2 хувиас илүү байх ёстой². Тухайн үед БНСУ-ын Засгийн газраас Хөндэ, Самсунг, Элжи, Поско, Эскей зэрэг цөөн тооны компанийг ТХЭ-ээр

сонгон санхүү, татварын болон бусад хөнгөлөлтүүдийг олгох болсон. ТХЭ нь бараа үйлчилгээний худалдаанаас гадна уул уурхай, хөрөнгө оруулалт, технологи дамжуулалт гэх зэрэг бүх төрлийн хил дамнасан бизнест хөнгөлөлт эдлэх боломжтой. ТХЭ-чдэд гадаад зах зээлийн мэдээллийг түрүүлж авах, гадаадын томоохон төсөлд давуу эрхтэйгээр оролцох, жижиг дунд үйлдвэрлэгчдийн барааг өөрийн сүлжээгээр дамжуулан экспортлох зэрэг боломжийг төрөөс олгож байв. Түүнээс гадна гадаад худалдаанд татвар, санхүүгийн хөнгөлөлтүүдийг эдэлж байсны дүнд тэдний бизнесийн цар хүрээ, борлуулалт хурдацтай өсөж, дотоодын зах зээлд үлэмж байр суурь эзлэх болсон. Засгийн газар нь хяналт, хариуцлагын тогтолцоог үр ашигтай байлгах үүднээс цөөн тооны компанийг ТХЭ-ээр сонгож бусдаас илүү боломж олгож байв³. 2009 онд нэгэнт үр дүнгээ өгсөн ТХЭ хөтөлбөрийг зогсоосны дараа гадаад худалдааны хуульд өөрчлөлт оруулж дунд үйлдвэрлэгчдийн шууд бус экспортыг дэмжих зорилгоор Мэргэшсэн худалдаа эрхлэгч хөтөлбөрийг 2014 оноос албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөр нь дотоод гадаад зах зээлд компанийн нэр хүндийг өсгөж, гадаад худалдаанд бусдаас давуу тал олгож байгаагаараа ТХЭ хөтөлбөртэй төстэй юм. Өнөөгийн байдлаар БНСУ-д 627 мэргэшсэн худалдаа эрхлэгч компани үйл ажиллагаа явуулж байна⁴.

² 종합상사 (naver.com)

³ Role of Subsidy in Evolution of Platform Intermediary: Focus on Government Support for General Trading Companies, Chanhi Park, 2022. E-Trade Review, Vol.20, No.4(November 30, 2022) pp.63-87.

⁴ 한국무역협회 전문무역상사 CTCnet (kita.net)

1.3 Хэвтээ интеграцийн бодлого

1979 оноос томоохон корпорацуудын бизнесийн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулалтад оруулах зорилгоор хэвтээ интеграцийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Түүхий эд бэлтгэлээс боловсруулалт, үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалт хүртэлх шат дамжлагуудыг төрөлжүүлэн, өөр өөр аж ахуйн нэгжид хариуцуулан зохион байгуулснаар үйлдвэрлэлийн хурд, бүтээмж нэмэгдэж, гарц болон ашгийн хэмжээ өсдөг байна. БНСУ-ын Хөндэ автомашины үйлдвэрлэл бол хэвтээ интеграцийн томоохон жишээ юм. Хөндэ ган хайлуулах үйлдвэр нь төмөр бэлдэц, Хөндэ виа компани нь автомашины эд анги, Хөндэ мобис нь үйлдвэрлэлийн шугам болон тест, Хөндэ капитал компани нь зээл санхүүжилт, Хөндэ глобус компани нь тээвэр логистик, Хөндэ автомашин нь угсралт болон худалдааг тус тус хариуцан, интеграци хэлбэрээр ажилладаг. Өнөө цагт тус улсын үндэстэн дамнасан корпорацууд нь хэвтээ интеграцийн зарчмаар ажиллаж байна.

1.4 Өмнө хэрэгжсэн бодлого, хөтөлбөрүүдийн үр дүн

1962 оноос эхлэн хэрэгжүүлсэн Эдийн засгийг хөгжүүлэх үечилсэн төлөвлөгөөнүүдэд үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүдийг тусган хэрэгжүүлж иржээ. Эдгээр бодлогын эхний үе шат нь улс орны санхүү, эдийн засгийн чадвар сайнгүй, үйлдвэрлэлийн бааз

суурь хөгжөөгүй байсан тэр цаг үед аж үйлдвэрлэлийн суурь, дэд бүтцийг бий болгоход чиглэгдэж байв. Хүнд аж үйлдвэрлэлийг гадаадын хөнгөлөлттэй зээлээр дэмжих бодлогод хийсэн Чой Жэду, А.Левченко нарын судалгаагаар уг зээлд хамрагдсан компаниудын дараагийн 30 жилийн борлуулалт нь хамрагдаагүй компаниудтай харьцуулахад үлэмж өндөр дүнтэй гарсан байна⁵. Бодлогын хоёрдугаар шат нь олон улсын худалдааны орчин өнөө үетэй харьцуулахад төдийлөн сайнгүй, дотоод дахь ААН-үүдийн худалдааны мэдлэг чадвар хомс байсан тэрхүү цаг үед гадаад худалдааны томоохон дэд бүтцийг бий болгох замаар үндэсний үйлдвэрлэгчдийн экспортыг дэмжихэд чиглэжээ. Ингэхдээ гадаад худалдаанд корпорацуудад давуу тал олгох замаар тэдний эдийн засаг дахь үүрэг, нөлөөг нэмэгдүүлсэн нь үр өгөөжөө өгсөн. 1962-1992 оны хооронд үе шаттайгаар, харилцан уялдаатай хэрэгжүүлсэн 6 удаагийн 5 жилийн төлөвлөгөөний үр дүнд тус улсын эдийн засаг өндөр хурдацтай өссөн бөгөөд нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 1961 онд 83 ам доллар байсан бол 1992 онд 6479 ам доллар болж 80 дахин өсжээ. Мөн аж үйлдвэрлэл нь бүтцийн хувьд нэгдүгээр шатны үйлдвэрлэлээс хүнд болон химийн үйлдвэрлэлд шилжсэн⁶. Дээрх хугацаанд БНСУ-ын аж үйлдвэрлэл нь дараах үе шатыг дамжин хөгжжээ.

БНСУ-ын аж үйлдвэрлэлийн хөгжлийн замнал: Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл → өргөн хэрэглээний барааны

⁵ The long-term effects of industrial policy, Jaedo Choi, Andrei A. Levchenko 2022.

⁶ 경제개발 5개년계획(한국) (naver.com)

экспорт, завсрын бүтээгдэхүүний гурил зэрэг бүтээгдэхүүн) үйлдвэрлэл (үйлдвэрлэлийн процессоор дамжиж → завсрын бүтээгдэхүүн болон эцсийн бүтээгдэхүүн болдог төмөр, технологийн бүтээгдэхүүний экспорт

2. Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, арга хэмжээнүүд

БНСУ-ын Засгийн газар нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголт, татаас, хөнгөлөлттэй зээл зэрэг уламжлалт аргуудаас гадна төрийн шууд оролцоо бүхий зохицуулалтын шинжтэй олон төрлийн экспортыг дэмжих арга хэрэгслүүдийг ашиглан дотоодын үйлдвэрлэгчдийн экспортыг дэмжиж байна. Өмнө хэрэгжүүлсэн бодлого хөтөлбөрүүдийн үр дүнд корпорацууд бие даан экспорт хийх болсон учир Засгийн газар нь 2000 оноос эхлэн жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийг дэмжихэд анхаарлаа хандуулсан. 2010 оноос тэдэнд тулгамдсан хүний нөөц, санхүү, борлуулалтын асуудлуудыг шийдвэрлэх нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх болов⁷.

БНСУ-ын ЖДҮ эрхлэгчдийг дотоод зах зээлд бараа үйлчилгээ нийлүүлэгч, бие даан экспортлогч, корпорацын туслан гүйцэтгэгч гэсэн 3 бүлэгт хувааж болно. Засгийн газрын бодлого

нь дотоод зах зээлд бараа үйлчилгээ нийлүүлэгчдийг гадаад зах зээлд гаргах, экспортлогчдын үйлдвэрлэл, худалдааны чадавхыг дээшлүүлэхэд чиглэгддэг. БНСУ-ын нийт ЖДҮ эрхлэгчдийн 10 орчим хувь нь экспорт хийдэг⁸ байна. 2021 оны байдлаар тус улсад бүртгэлтэй ААН-үүдийн 99 хувь нь бичил болон жижиг дунд бизнесийн ангилалд хамрагдаж байгаа бол хувийн хэвшилд ажиллагсдын 83,2 хувь нь уг салбарт ажиллаж байна⁹.

Засгийн газар нь гол харилцагч орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр хийх замаар бизнес эрхлэгчдийн импорт, экспортын үйл ажиллагааг хөнгөвчилж ирсэн. Үйлдвэрлэл болон гадаад худалдааг хариуцсан яамд нь экспортыг дэмжихэд нягт холбоотой ажилладаг. Яамдын бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй, Засгийн газрыг төлөөлөх эрх бүхий Худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг (KOTRA),

Хүснэгт 1. БНСУ-ын жижиг дунд бизнесийн шалгуур¹⁰


	Жижиг бизнес	Дунд бизнес
1 Борлуулалт (3 жилийн дундаж)	12 тэрбум воноос бага	150 тэрбум воноос бага
2 Нийт хөрөнгийн хэмжээ	500 тэрбум воноос бага	

⁷ “중소기업 지원정책의 효과에 관한 연구: 중소기업 성장단계의 조절효과와 반복적 정부지원의 효과를 중심으로”, 장현주. 2018.

⁸ 통계자료홈 - 통계자료 - 중소기업부 (mss.go.kr)

⁹ e-나라지표 메인화면 (index.go.kr)

¹⁰ 별표·서식 (law.go.kr), <https://www.mss.go.kr/site/smba/01/10106060000002016101111.jsp>



Зураг 1. Бодлого хөтөлбөр хэрэгжих шат дамжлага

Худалдааны хороо (KITA), Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих агентлаг (KOSMES) зэрэг итгэмжлэгдсэн 19 байгууллага ажиллаж байна¹¹. Ихэнх итгэмжлэгдсэн агентлагуудын үйл ажиллагааны чиглэлийг төрөөс хуульчилж өгсөн байдаг. Олон жил нэг чиглэлээр тасралтгүй ажилласан эдгээр агентлаг нь асар их мэдлэг, туршлага хуримтлуулсан байдаг онцлогтой. Итгэмжлэгдсэн агентлагуудын дор бодлого хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн мэргэшсэн байгууллагууд ажилладаг. Тэд төрийн үйлчилгээг зорилтот бүлэгт үзүүлдэг. Хэрэгжүүлэгч байгууллагад арилжааны банкнуудаас гадна гадна зөвлөгөө, сургалт, судалгаа, орчуулга, даатгал, сурталчилгаа, тээвэр зэрэг үйлчилгээ үзүүлдэг ААН-үүдийг хамруулна. Засгийн газрын итгэмжлэгдсэн агентлагуудаас гадна орон нутгийн өөрөө удирдах

байгууллагууд, үйлдвэрлэл үйлчилгээний нэгдсэн холбоод Засгийн газраас санхүүжилт авч экспортыг дэмжих үйл ажиллагаанд оролцох явдал түгээмэл болжээ.

Итгэмжлэгдсэн агентлагууд нь төлөвлөсөн хөтөлбөр, үйлчилгээгээ зорилтот бүлгийн онцлог, чадамж, үйлдвэрлэл болон бизнесийн хэв маягт тохируулан уян хатан байдлаар үр ашигтай хүргэхийг зорьдог. Экспортыг дэмжиж буй арга хэрэгслүүдийг хилийн чанадын болон дотоодын гэж ангилж болно. КОТРА¹² (83 улсад 128 салбартай), Солонгосын худалдааны хороо¹³ зэрэг агентлагуудын гадаад дахь салбаруудаар дамжуулан хэрэгжүүлдэг зах зээлийн судалгаа, сурталчилгаа, компанийг төлөөлөх, бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, түгээх зэргийг хилийн чанадын үйлчилгээнд хамруулна. БНСУ-ын газар нутагт хэрэгждэг

¹¹ A Study of the Export Support System's Utilization Performance for Small and Medium-Sized Enterprises. Choi Gang Woo, 2021.

¹² 코트라 무역투자 24 (kotra.or.kr)

¹³ 한국무역협회-KITA.NET

экспортыг дэмжих бүх төрлийн арга хэрэгслийг дотоод үйлчилгээнд тооцно. Эдгээрийг хэрэгжүүлж буй зорилгын хүрээнд санхүүгийн, маркетингийн, технологийн гэж гурав ангилж болно.

2.1 Санхүүгийн дэмжлэг

Үйлдвэрлэгч гадаад зах зээлд нэвтрэхэд урьд өмнө байгаагүй олон төрлийн нэмэлт зардлууд гардаг. Бүтээгдэхүүнийг импортлогч талын стандартад нийцүүлэхийн тулд үйлдвэрлэлийн процесст нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарах нь ч бий. Үйл ажиллагаа нь бүрэн тогтворжоогүй жижиг дунд үйлдвэрлэгчид санхүүгийн дэмжлэггүйгээр экспорт хийнэ гэдэг бараг боломжгүй учир төрөөс экспортыг дэмжих төрөл бүрийн хөнгөлөлттэй зээл олгодог байна. Зээлийн санхүүжилтийг арилжааны банкууд гардан хэрэгжүүлдэг. Тухайлбал, ЖДҮЯ нь 2023 онд 4,2 их наяд воны санхүүжилт зарласан¹⁴. Зээлийн нөхцөл шалгуураар дамжуулан Засгийн газар нь зарим төрлийн дэмжлэг, хязгаарлалтын зохицуулалт хийх нь түгээмэл. Тухайлбал 2023 онд эрчим хүчний өндөр хэмнэлттэй, хорт хаягдал бага ялгаруулдаг үйлдвэрлэлийг маш бага хүүтэй зээлээр дэмжиж байна. Экспортын санхүүжилтээс гадна зээлийн баталгаа гаргах, хөнгөлөлттэй татвар болон даатгалын үйлчилгээнүүдийг санхүүгийн дэмжлэгт хамруулна¹⁵. Засгийн газар нь ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэгийг

томоохон корпорацуудаас хавьгүй илүү таатай нөхцөлөөр хүргэдэг байна. Тухайлбал, зээлийн хялбар нөхцөл болон бага хүү санал болгох, зээлийн баталгаа гаргаж өгөх, даатгалын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх гэх мэт.

Зээлийн баталгаа: Засгийн газар нь ЖДҮ эрхлэгчдийн экспортын гэрээ, шинэ технологи, өсөх ирээдүйтэй бизнес төлөвлөгөө зэрэгт үндэслэн зээлийн баталгаа (зээл авах эрх) гаргаж өгдөг. Энэ нь барьцаа хөрөнгөгүй ААН-үүдэд үйлдвэрлэлээ тасралтгүй явуулах боломж олгох бөгөөд, шинээр эхэлж буй бизнест эргэлтийн хөрөнгө болж өгдөг байна. Хүсэлт гаргасан ААН-ийн бодит үнэ цэн, санхүүгийн чадвар, технологийн түвшин, бизнесийн ирээдүй, хүний нөөцийн чадвар зэргийг үнэлж, зээлжих зэрэглэлийг тогтоосны үндсэн дээр зээлийн баталгаа гаргадаг. ААН нь зээлийн баталгаанд үндэслэн арилжааны банкнаас зээл авч үйлдвэрлэлээ хэвийн явуулах боломж бүрддэг байна. БНСУ-ын Санхүүгийн зохицуулах хорооны харьяа Зээлийн баталгааны сан нь уг үйлчилгээг 1976 оноос хойш хэрэгжүүлж байна¹⁶.

Худалдааны даатгал: ААН-үүдийн худалдааны болон гадаад зах зээлд нэвтрэх үйл ажиллагаатай холбоотой эрсдлийг даатгах замаар үйл ажиллагааны үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ юм. Үүнд экспортын даатгал, импортын даатгал, валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлээс сэргийлэх

¹⁴ 중소기업진흥공단 (kosmes.or.kr)

¹⁵ “Problems and Improvement of Export Financing Support Programs for SME in Korea”, Yeong-Ae Kim, 2017.

¹⁶ 신용보증기금 (kodit.co.kr)

даатгал, хөрөнгө оруулалтын эрсдлийн даатгалаас гадна хамтран ажиллахаар зорьж буйг гадаад компанийн санхүүгийн чадварыг судлах зэрэг үйлчилгээг хамруулна. БНСУ-ын Үйлдвэрлэл, худалдаа, нөөцийн яамны харьяа Худалдааны даатгалын корпораци нь уг үйлчилгээг гардан хэрэгжүүлдэг мэргэшсэн байгууллага юм¹⁷.

2.2 Маркетингийн дэмжлэг

БНСУ-ын экспортыг дэмжих хөтөлбөрүүд дотроос хамгийн олон төрөл хэлбэртэй нь компанийг гадаад зах зээлд нэвтрүүлэх экспортын маркетингийн үйлчилгээ юм. Үүнд бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд сурталчлан таниулах, үйлдвэрлэгчдэд гадаад худалдааны дэд бүтэц бий болгох, ажилтнуудын худалдааны мэдлэг чадварыг дээшлүүлэх зэрэг үйлчилгээг хамруулна. Томоохон корпорацууд нь өөрийн эзэмшлийн гадаад худалдааны дэд бүтэц эзэмшдэг (*гадаад дахь бараа бүтээгдэхүүний зар сурталчилгаа, борлуулалт, хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн суваг*) учир маркетингийн дэмжлэг нь ЖДҮ эрхлэгчдийг дэмжихэд чиглэгддэг байна. Засгийн газар нь корпорацуудын эзэмшлийн энэхүү бэлэн дэд бүтцийг ЖДҮ эрхлэгчдэд ашиглуулах тохиолдол бий. Экспортын маркетингийн үйлчилгээ нь итгэмжлэгдсэн агентлагуудын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй. Тухайлбал, КОТРА нь хилийн чанадад зах зээлийн судалгаа хийх, экспортын стратеги боловсруулах,

бараа бүтээгдэхүүн сурталчлах, борлуулалт болон тээвэрлэлтийн суваг бий болгох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг үйлчилгээ үзүүлдэг бол Солонгосын худалдааны хороо нь сургалт хийх, зөвлөгөө өгөх, худалдааны статистик мэдээллээр хангах, орчуулга хийх, экспортын брэнд хөгжүүлэх, бүтээгдэхүүний загвар дизайныг сайжруулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг үйлчилгээг орон нутгийн салбаруудаар дамжуулан хэрэгжүүлж ирсэн. Итгэмжлэгдсэн агентлагууд хамтарсан болон бие даасан хэлбэрээр экспортыг дэмжих багц хөтөлбөрүүдийг зарлан хэрэгжүүлэх явдал түгээмэл. Тухайлбал ЖДҮЯ болон ҮХНЯ-ны харьяа агентлагууд 2022 онд Экспортын ваучер, Экспортын консорциум, Экспортын инкубатор, Онлайн экспортын платформ зэрэг 9 хөтөлбөр зарлаж, үүнд 16.000 ААН-ийг хамруулжээ¹⁸. Илүү тодорхой ойлголт өгөх үүднээс Экспортын ваучер үйлчилгээг дэлгэрүүлж авч үзье. Итгэмжлэгдсэн агентлагуудын олон төрлийн үйлчилгээнээс ААН нь өөрийн эрхэлдэг бизнесийн онцлогт тохирсон тодорхой тооны үйлчилгээг байгууллагын харьяалал харгалзахгүй багцлан сонгож авахыг экспортын ваучер гэдэг. Жишээ нь А компани Экспортын ваучерийн хүрээнд КОТРА-гийн компанийг хилийн чанадад төлөөлөх, Худалдааны хорооны экспортын стратеги боловсруулах, Худалдааны даатгалын корпорацийн экспортын даатгалын хөнгөлөлт

¹⁷ 한국무역보험공사 (ksure.or.kr)

¹⁸ A Study on the Utilization and Performance of Online Export Marketing Support System for SMEs: A Focus on Daejeon, Sejong, and the Chungnam Provinces. Seong-Ho Heo, Jang-Woo Choi. 2022.

зэрэг үйлчилгээг авах боломжтой. Бизнесийн төрөл, борлуулалтын орлого, экспортын хэмжээнээс хамаарч ваучерын үнийн дүн харилцан адилгүй байна. Тухайлбал, 2022 онд өмнөх жилийн тайлант хугацаанд

1 сая хүртэл ам. долларын экспорт хийсэн үйлдвэрлэгчид 50 сая воны, 1-5 сая ам. долларын экспорт хийсэн үйлдвэрлэгчид 70 сая воны ваучер олгожээ.

Хүснэгт 2. Экспортын ваучераар авах боломжтой үйлчилгээний жагсаалт¹⁹

№	Нэр	Тайлбар
1	Судалгаа, зөвлөгөө	Хамтрагч, худалдан авагч болон түүхий эд нийлүүлэлтийн суваг илрүүлэх, гадаад зах зээлийн, хэрэглэгчийн, өрсөлдөгч бүтээгдэхүүний, гадаад компанийн санхүүгийн чадварын судалгаа. Байгууллагын дунд, урт хугацааны өсөлтийн стратеги, экспортын стратеги төлөвлөх болон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаад зах зээлд нэвтрэх болон маркетингийн стратегийн, менежментийн зөвлөгөө.
2	Экспортын орчуулга	Гэрээ, хууль, цахим контент, мобайл апп, бизнесийн болон технологийн баримт бичиг, цахим хуудас зэргийг орчуулах. Мөн бусад бүх төрлийн аман орчуулга.
3	Экспортын чадварыг дээшлүүлэх сургалт	Худалдаа, глобал маркетинг, бизнесийн ярилцлага, зорилтот зах зээлд нэвтрэх, Хятадын зах зээлийн цахим сургалт, байгууллагын дотоод чадварыг дээшлүүлэх, стратегийн бүтээгдэхүүн, худалдааны баримт бичгийн мэргэжилтэн бэлтгэх, глобал бизнесийн мэргэжилтэн бэлтгэх, гадаад зах зээлд нэвтрэх процесс, оюуны өмчийг бүртгүүлэх, оюуны өмчийн маргаан зохицуулах зэрэг сургалт.
4	Тусгай зөвшөөрөл, оюуны өмч	Гадаадад оюуны өмчийг бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл, батламж болон импортын зөвшөөрөл авах стратегийн зөвлөгөө, оюуны өмчийн маргаанд туслах, AEO (authorized economic operator) буюу Худалдааны хүлээн зөвшөөрөгдсөн компанийн гэрчилгээ авахад туслах зэрэг үйлчилгээ.
5	Бичиг баримт боловсруулах, арилжааны даатгал	Гэрээний загвар бэлдэх. Гааль, тээвэр, төлбөрийн, мөн ЧХХ-ийн гарал үүсэл, цахим худалдаатай холбоотой баримт бичиг боловсруулах. Тухайн улсад хуулийн этгээд байгуулах, бүртгүүлэх, худалдааг төлөөлөн хийх, Засгийн газрын худалдан авалтад оролцох, валют арилжааны даатгалд хамрагдахад туслах зэрэг.
6	Компанийг гадаадад таниулах	Компани, бүтээгдэхүүн, брэндийн сурталчилгааг телевиз, сонин, сэтгүүлээр хийх. SNS, search engine marketing, viral marketing, internal marketing communication зэрэг маркетинг сурталчилгааны арга хэрэгслүүдийг ашиглана.
7	Брэнд хөгжүүлэх	Экспортын брэнд, онлайн болон оффлайн хэлбэрийн барааны танилцуулга бэлдэх, брэндийн баталгаажуулалт хийх, хуурамч үйлдвэрлэлээс сэргийлэх зэрэг.

¹⁹ 수출지원기반활용사업 > 사업안내 > 수출바우처 사업 (exportvoucher.com)

№	Нэр	Тайлбар
8	Үзэсгэлэн худалдаанд хамруулах	Дотоодод зохиогддог олон улсын үзэсгэлэн худалдаанд хамруулж гадаад худалдан авагчтай уулзуулах, семинар, бүтээгдэхүүний танилцуулгад хамруулах. Гадаад худалдан авагчийг урьж ирүүлэн уулзуулах болон бүтээгдэхүүн танилцуулах, семинар хийх. Гадаадын төсөлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ.
9	Хууль, татвар, санхүүгийн зөвлөгөө	Аудит, санхүүгийн шалгалт, санхүүгийн зөвлөгөө, хуулийн зөвлөгөө, хуулийн этгээд байгуулах. Гадаад улсад үүссэн маргаан таслахад туслах, гадаадад хуулийн этгээд байгуулах зэрэг экспорттой холбоотой зөвлөгөө.
10	Дизайн хөгжүүлэлт	Гадаад хэл дээр цахим каталог бүтээх, савлагааны загвар гаргах, цахим хуудас хийх, цахим апп бүтээх. Гадаадын цахим худалдаанд хуудас нээх, бүтээгдэхүүний загвар гаргах, компанийн болон бизнесийн танилцуулга хийх үйлчилгээ.
11	Видео танилцуулга	Гадаад зах зээлд нэвтрэхэд шаардлагатай дүрс бичлэгийн танилцуулга сурталчилгаа бүтээх үйлчилгээ.
12	Гадаадын стандартын шалгуур	Импортын стандарт баталгаажуулах зардлыг төлөх. Эрүүл ахуй аюулгүй байдал, халал зэрэг импортлогч талын стандарт шалгуурыг хангах, импортын зөвшөөрөл авахад туслах үйлчилгээ.
13	Олон улсын тээвэр	Далайн болон агаарын тээврийн зардал, даатгалын төлбөрөөс хөнгөлөх /дотоодод болон экспортлогч улсад гарах зардал/

ААН нь хамрагдаж буй хөтөлбөрийн үнийн дүнгийн тодорхой хувийг хариуцдаг журамтай. Экспортын ваучер хөтөлбөрт хамрагдахын тулд ААН нь ваучерын үнийн дүнгийн 30-50 хувийг төлнө. Хөтөлбөрт хамрагдагч нь агентлагуудын олон төрлийн үйлчилгээнээс өөрт тохирсон хэдийг багцлан сонгосны дараа хэрэгжүүлэгч байгууллагыг сонгоно. Экспортын ваучер хөтөлбөрийн цахим хуудсанд үйлчилгээний жагсаалтаас гадна тухайн үйлчилгээг гардан хэрэгжүүлдэг 2044 компанийн²⁰ танилцуулга байна. Тухайн компани ямар төрлийн, аль улсын экспортод чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг, өмнөх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн

түвшин, мөн ямар төрлийн бизнес эрхлэгч уг байгууллагыг түлхүү сонгодог зэрэг статистик мэдээлэл нь экспортын ваучер хөтөлбөрийн цахим хуудсанд тавигдсан байдаг.

2.3 Технологийн дэмжлэг

Үйлдвэрлэл үйлчилгээний технологийг сайжруулах замаар бүтээмж, өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд технологийг дэмжих бодлогын зорилго оршдог. Өнөөгийн байдлаар ЖДҮЯ-наас “К брэнд”, “Hidden champion”, “К unicorn” зэрэг технологийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Технологийн баталгааны сан, Технологийн судалгааны хүрээлэн, Үйлдвэрлэлийн

²⁰ 수출지원기반활용사업 > 사업안내 > 수출바우처 사업 (exportvoucher.com)

технологийн ассоциаци зэрэг агентлагууд технологи хөгжүүлэлт, дамжуулалт болон технологийн үйлдвэрлэлийг дэмжих үүрэгтэй. БНСУ нь аж үйлдвэрлэлийн болон мэдээллийн технологийг санхүүгээр дэмжихээс гадна дараах хэдэн үндсэн аргуудыг ашиглаж байна.

1. Туршилт, судалгаа хөгжүүлэлтийг дэмжих: Үйлдвэрлэлийн технологийн ассоциац²¹ зэрэг байгууллага нь эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд болон үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааг дэмжих замаар шинэ технологийн туршилт, судалгааг дэмждэг.
2. Шинэ технологид зээл олгох: Технологийн баталгааны сан нь ААН-үүдийн эзэмшиж буй өсөх ирээдүйтэй шинэ технологид баталгаа гарган зээл олгох замаар шинэ технологийн үйлдвэрлэлийг дэмждэг²².
3. Түүхий эдийн нөөц бүрдүүлэх: Байгаль орчин, уул уурхайн корпорац нь өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох газрын ховор элемент, хром, молибден, селен зэрэг стратегийн металлуудийг дотоодод их хэмжээгээр нөөцөлдөг²³. Энэ нь үйлдвэрлэгчид түүхий эдийн хомсдолд орж үйл ажиллагаа доголдохоос сэргийлэх

зорилготой. Түүхий эдийн нөөцөөс ААН-үүдэд худалдах, зээлээр олгох үйлчилгээ үзүүлдэг.

4. Бүтээгдэхүүнийг импортлогч улсын стандарт шалгуурт нийцүүлэхэд туслах: Экспорт хийхэд тулгардаг дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын CE, NRTL, RoHS зэрэг 160 орчим технологийн стандарт шаардлагыг хангахад дэмжлэг үзүүлдэг²⁴.
5. Худалдан авалтыг дэмжих захиргааны арга: БНСУ-ын төрийн худалдан авалтын 50 буюу түүнээс дээш хувь нь ЖДҮ-ийн бараа бүтээгдэхүүн, түүний 15-аас дээш хувь нь технологийн бүтээгдэхүүн байх хуультай²⁵. Мөн Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар бусад оронд нийлүүлдэг тоног төхөөрөмжийн дийлэнх нь дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн байх журамтай.
6. Мэдээллийн технологийн компаниудын экспортыг дэмжих: АНУ-ын цахиурын хөндий болон Япон, Хятад улсуудад дотоодын компаниудын мэдээллийн технологийн экспортыг дэмжих төвүүдийг ажиллуулдаг. Мөн AI EXPO, IT EXPO, ICT convergence Korea зэрэг олон

²¹ КОITA 한국산업기술진흥협회

²² 한국생산기술연구원 | KITECH

²³ 국제협력 < 사업소개 한국광해광업공단 (komir.or.kr)

²⁴ “우리나라 중소기업 수출지원제도 인지수준과 활용에 관한 연구” 오병석, 2013.

²⁵ 중소기업제품 공공구매 종합정보망 (smpp.go.kr)

улсын чанартай мэдээллийн технологийн томоохон үзэсгэлэнг дотоодод тогтмол зохион байгуулдаг.

а. Үйлчилгээний экспортыг дэмжиж буй байдал

БНСУ 1990-ээд оны сүүлээс үйлчилгээний экспортод анхаарлаа хандуулж эхэлсэн. Энэ үед барааны экспортыг дэмжиж ирсэн үндсэн арга хэрэгслүүдийг үйлчилгээний экспортыг дэмжихэд ашиглаж байв. Сүүлийн жилүүдэд үйлчилгээний экспортыг дэмжих төрөлжсөн байгууллагууд олноор бий болсны дүнд ААН-үүд өөрийн бизнесийн онцлогт тохирсон дэмжлэгийг авах боломж бүрдэж байна. Тухайлбал Соёл, спорт, аялал жуулчлалын яамны харьяа Контент үйлдвэрлэлийг дэмжих төв нь 2023 онд 624 тэрбум воны санхүүжилтээр кино, видео тоглоом, хүүхэлдэйн кино, аниме зэрэг цахим контентын экспортыг олон төрлийн арга хэрэгслээр дэмжиж байна²⁶. Тухайлбал дүрс бичлэгийн студи, концертын танхимаа үнэгүй ашиглуулах, мэргэжил дээшлүүлэх сургалт хийх, гадаад зах зээлд гарахад туслах, шилдэг зохиол шалгаруулж бүтээл болгоход дэмжлэг үзүүлэх зэрэг олон хэлбэртэй. Шинжлэх ухаан технологи, мэдээлэл харилцаа холбооны яамны харьяа Мэдээллийн технологийг дэмжих төв нь “Хиймэл оюун ухаанд суурилсан эрүүл мэндийн дижитал системийг дэмжих хөтөлбөр”,

“Хиймэл оюун ухаанд суурилсан хагас дамжуулагчийн кластер”, “Үйлчилгээний программ хангамжийг дэмжих төсөл” зэрэг мэдээллийн технологийн үйлдвэрлэл, экспортыг дэмжих 100 гаруй хөтөлбөр, үйлчилгээг хэрэгжүүлж байна²⁷. 2021 оны байдлаар үйлчилгээний сектор нь нийт экспортын 16 хувийг эзэлж байгаа бол ДНБ-ий 60 орчим хувийг бүрдүүлж байна²⁸. Үйлчилгээний экспортын дийлэнх хэсэг нь технологийн бараа бүтээгдэхүүний экспортын хавсарга буюу программ хангамж, засвар үйлчилгээ, сургалт, суурилуулалт, зөвлөх үйлчилгээ хэлбэртэй байна.

БНСУ-ын эрдэмтдийн судалгаагаар өнөөгийн экспортыг дэмжих хөтөлбөр, арга хэрэгслүүдэд давхардсан, ижил төстэй үйлчилгээ олон байгаагийн дээр хөтөлбөрт хамрагдахын тулд бизнес эрхлэгчдээс төлдөг төлбөрийн хэмжээ өндөр, хөтөлбөрт хамрагдах үйл явц ойлгомжгүй, хугацаа их зарцуулдаг зэрэг сул талууд байна. Тухайн хөтөлбөр олонд танигдсан байх тусам хамрагдах компанийн тоо их, гарах үр дүн өндөр байдаг байна. Мөн хөтөлбөрт хамрагдах компанийн хэмжээ нь хөтөлбөрийн үр дүнтэй шууд хамааралтай байдаг нь судалгаагаар тогтоогджээ. Компанийн хэмжээ том байх тусам хөтөлбөрийн үр дүн өндөр байдаг бол эсрэгээрээ жижиг компаниуд хөтөлбөрт хамгийн их хамрагддаг боловч экспорт хийх оролдлого хамгийн бага²⁹ байна.

²⁶ 한국콘텐츠진흥원 (kocca.kr)

²⁷ 사업리스트 - - 전체 - 지원분야 - 주요사업 - 정보통신산업진흥원 (nipa.kr)

²⁸ www.trademap.org

²⁹ A Study on the Utilization and Performance of Online Export Marketing Support System for SMEs. Seong-Ho Heo, 2022.

Дүгнэлт

БНСУ нь үйлдвэрлэл болон гадаад худалдааг хөгжүүлэхэд тулгарсан цаг үеийн шинжтэй саад бэрхшээлүүдийг төрийн оновчтой бөгөөд тууштай бодлого, төр-хувийн хэвшлийн харилцан үр ашигтай хамтын ажиллагаагаар амжилттай даван туулж иржээ. Бүх бодлого хөтөлбөр нь хувийн хэвшлийн бизнес болон үйлдвэрлэлийг дэмжих, тэдэнд зах зээлийн орон зай гаргаж өгөхөд чиглэгдэж байна. Сүүлийн жилүүдэд бараа болон үйлчилгээний ЖДҮ эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжиж байна. Экспортыг дэмжих бодлого хөтөлбөр гаргах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дээрээс доош шаталсан, харилцан уялдаа бүхий нэгдсэн цогц систем хэлбэртэй байна. Үүнд төр болон хувийн хэвшлийн асар олон тооны байгууллага хамрагдах бөгөөд тэдний ажил үүргийн хуваарилалт, үүрэг оролцоо, үйл ажиллагааны арга барил нь хэвшин тогтжээ. Бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх шатанд Засгийн газрын итгэмжлэл бүхий мэргэшсэн агентлагууд гол үүрэг гүйцэтгэж байна. Үйлдвэрлэл, экспортыг тууштай дэмжиж өндөр амжилтад хүрсэн БНСУ-ын туршлагаас Монгол Улсад санаа авах зүйл олон. Үүнийг нарийвчлан тодорхойлохын тулд тус улсын санхүү, маркетинг, технологийн дэмжлэгүүд, Засгийн газрын итгэмжлэгдсэн агентлагуудын чиг үүрэг, уялдаа холбоо, үйл ажиллагааны арга барилаас Монгол Улсад хэрэгжүүлэх, санаа авах боломжтой зүйлсийг илүү дэлгэрүүлэх, хоёр улсын нөхцөл байдлыг харьцуулан судлах шаардлага байна.

БНСУ-ын экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүд амжилттай хэрэгжихэд дараах хэдэн хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

1. Үйлдвэрлэл, экспортыг дэмжих үүрэгтэй яамд, харьяа агентлаг хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа өндөр түвшинд хүрчээ. Агентлагууд нэгдсэн хөтөлбөр боловсруулах, хамтран хэрэгжүүлэх явдал түгээмэл болсон байна.
2. Яамд болон агентлагуудын чиг үүрэг олон жилийн турш өөрчлөгдөлгүй тууштай явж иржээ. Тухайлбал Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлаг 1962 онд, Байгаль орчин уул уурхайн корпорац 1967 онд, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих агентлаг 1979 онд байгуулагдсан цагаас хойш үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөөгүй байна. Тууштай байдал нь салбартаа мэргэшиж, туршлага хуримтлуулах, улмаар өндөр амжилт олох үндэс болж байна.
3. Засгийн газар шаардлагатай мэдээллийг хувийн хэвшлээс гаргуулж авах эрх хуульчлагдсан байдаг, мөн эрдэм шинжилгээний байгууллагуудтай ойр хамтран ажилладаг нь гаргасан бодлого хөтөлбөр үр дүнгээ өгөх үндэс болдог байна.
4. Экспортыг дэмжих агентлагууд болон үйлчилгээ нь маш олон төрөл болж тэдний дунд өрсөлдөөн бий болсон. Бизнес эрхлэгч нь олон байгууллагын төрөл бүрийн үйлчилгээнээс өөрийн хэрэгцээнд тохирохыг олохын тулд сайтар судлах шаардлага гардаг байна.

Ном зүй

1. 경제 개발 5개년 계획 (naver.com)
2. 종합상사 (naver.com)
3. Role of Subsidy in Evolution of Platform Intermediary: Focus on Government Support for General Trading Companies, Chanhi Park, 2022. E-Trade Review, Vol.20, No.4(2022) pp.63-87.
4. THE LONG-TERM EFFECTS OF INDUSTRIAL POLICY, Jaedo Choi, Andrei A. Levchenko 2022. <http://www.nber.org/papers/w29263>
5. 한국무역협회 전문무역상사 CTCnet (kita.net)
6. 중소기업 지원정책의 효과에 관한 연구: 중소기업 성장단계의 조절효과와 반복적 정부지원의 효과를 중심으로, 장현주. 2018. Орч: ЖДҮ-ийг дэмжих бодлогын тухай судалгаа: ЖДҮ-ийн өсөлтийн хүчин зүйл, Засгийн газрын дэмжлэгийн үр дүнгийн тухай, Жан Хён Жү. 2018 он.
7. 한국의 공업 (naver.com)
8. 현황 : FTA 강국, KOREA
9. 통계자료홈 - 통계자료 - 중소벤처기업부 (mss.go.kr)
10. e-나라지표 메인화면 (index.go.kr)
11. 별표·서식 (law.go.kr), <https://www.mss.go.kr/site/smba/01/1010606000002016101111.jsp>
12. A Study of the Export Support System's Utilization Performance for Small and Medium-Sized Enterprises. Choi Gang Woo, 2021.
13. 코트라 무역투자 24 (kotra.or.kr)
14. 한국무역협회-KITA.NET
15. A Study on the Utilization and Performance of Online Export Marketing Support System for SMEs. Seong-Ho Heo, 2022.
16. “금융지원이 수출기업의 성과에 미치는 영향에 대한 실증분석”, 전기영, 2022. Орч: “Санхүүгийн дэмжлэгийн экспортлогчид үзүүлэх нөлөөллийн тухай судалгаа” Жон Ги Ён, 2022 он.
17. 중소벤처기업진흥공단 (kosmes.or.kr)
18. “Problems and Improvement of Export Financing Support Programs for SME in Korea”, Yeong-Ae Kim, 2017.
19. A Study on the Utilization and Performance of Online Export Marketing Support System for SMEs: A Focus on Daejeon, Sejong, and the Chungnam Provinces. Seong-Ho Heo, Jang-Woo Choi. 2022.
20. 수출지원기반활용사업 > 사업안내 > 수출바우처 사업 (exportvoucher.com)
21. “우리나라 중소기업 수출지원제도 인지도수준과 활용에 관한 연구” 오병석, 2013. Орч: “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн нэр хүнд болон хэрэглээний тухай судалгаа” У Бён Сөг, 2013 он.
22. 중소기업제품 공공구매 종합정보망 (smpp.go.kr)
23. 한국콘텐츠진흥원 (kocca.kr)
24. 사업리스트 - - 전체 - 지원분야 - 주요사업 - 정보통신산업진흥원 (nipa.kr)

Forms of government support for national production and export in the Republic of Korea

Myagmar Dashdavaa

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
myagmar_d@mas.ac.mn*

Abstract: *The study aims to draw valuable lessons for Mongolia from the Republic of Korea's (ROK) successful experiences in export support. Within this framework, the first section of the study provides an overview of key initiatives in industry and foreign trade development that have been implemented since the 1960s. The second section examines the comprehensive content, formats, and implementation methods of export support programs designed for small and medium-sized enterprises, particularly those in use since 2000. This section covers various aspects of export support, including financial assistance, marketing strategies, and technical services. It also includes illustrative examples. The study's findings recommend specific case studies and insights from South Korea's export development journey and currently operational programs, which have the potential to benefit Mongolia's own export efforts.*

Key words: *ROK, export, industry, small and medium sized enterprises, policy, program*

<i>The day of submission:</i>	2023.06.15
<i>Completion of review:</i>	2023.06.19
<i>Final decision for acceptance:</i>	2023.09.29